

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

**" LEGAL REGULATION OF THE EXECUTION OF CIVIL COURT
DECISIONS AND INTERPRETATIONAL ISSUES"**



Б.Золбоо

*ДХИС-ийн Сургалт судалгааны 403-р анги- Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн
багш, хошууч*

Товч утга: Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа иргэний болон захиргааны хэргийн гүйцэтгэх баримт бичигт дүн шинжилгээ хийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, эрх зүйн орчны нийцтэй байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шүүхийн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан, нөхцөлийг илрүүлэн цаашид авч хэрэгжүүлэх боломжит санал, зөвлөмжийг боловсрууллаа.

Түүнчлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг судалж харьцуулалт хийн өөрийн оронд хэрэгжүүлж болохуйц сайн туршлагыг нэвтрүүлэх талаар санал дэвшүүлсэн.

Abstract: The Capital City Court Enforcement Office analyzed the civil and administrative enforcement documents in which the enforcement process is being carried out, identified the difficulties encountered in the enforcement process, the compatibility of the legal environment, and the issues that are currently facing the enforcement process, identified the reasons and conditions for the insufficient implementation of court decisions, and developed possible proposals and recommendations for further implementation. In addition, the Federal Republic of Germany's legal regulations on civil enforcement were studied and compared, and good practices that can be implemented in our country were proposed.

Keywords: executors, judgments, human rights, freedoms, and actual fulfillment.

Түлхүүр үг: шийдвэр гүйцэтгэгч, шүүхийн шийдвэр, хүний эрх, эрх чөлөө, бодит биелэлт.

НЭГ. УДИРТГАЛ

Монгол улсад өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Үндсэн хуульд тусгалаа олсон хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн баталгааг төр бүрдүүлж, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд эрх ашгийг нь хамгаалах чиглэлээр олон хуулийг шинэчлэн баталсны нэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль юм. Шинэчлэн найруулсан энэхүү хуулийн үзэл баримтлалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулахаар заасан. Энэ хуулийн хүрээнд шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэр, эрх зүйн баримт бичгийн үндсэн дээр бусдын хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрх ашгийг сэргээж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахтай холбогдсон нийгмийн тодорхой харилцаа зохицуулагдаж байна. Өөрөөр хэлбэл, иргэний хэргийг хянан шийдвэрлээд шүүхээс гаргасан шийдвэр, шүүхээр баталгаажуулсан нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, захиргааны шийтгэвэр, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг төрөөс эрх олгогдсон байгууллага болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр энэ хуулиар зохицуулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсөн хэн боловч шүүхэд гомдол, нэхэмжлэл гарган зөрчигдсөн эрхээ сэргээлгэх бөгөөд хариуцагч шүүхээс хүлээлгэсэн гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг сайн дурын үндсэн дээр биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа хийгддэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шуурхай, үр нөлөөтэй хэрэгжсэнээр Үндсэн хуулиар баталгаажсан энэхүү эрх бүрэн хангагдана.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн төлбөр төлөгчийн төлбөрийн чадвараас шууд шалтгаалдаг бөгөөд нэхэмжлэгчээс эд хөрөнгийг шүүхийн шатанд хамгаалуулах арга хэмжээг авхуулаагүйгээс төлбөр төлөгч эд хөрөнгөө нуух, бусдад шилжүүлж үрэгдүүлснээр төлбөрт гаргуулах эд хөрөнгө тогтоогдохгүй байх, төлбөрөөс зайлсхийдэг, салбар хуулиуд, хуулийн бусад байгууллагын хамтын ажиллагаа уялдаа холбоо хангалтгүй, мөн захиргааны байгууллага албан тушаалтан шүүхийн шийдвэр биелүүлдэггүй, биелүүлэхээс зайлсхийдэг зэрэг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах томоохон шалтгаан болж байна.

Энэхүү илтгэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч буй бэрхшээл, тулгамдсан асуудлын шалтгаан, үндэслэлийг илрүүлэн цаашид шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг нэг мөр хангах арга замыг тодорхойлж бусад улсын сайн туршлагыг судалсны үндсэн дээр санал, зөвлөмж дэвшүүлэхийг зорилоо.

ХОЁР. ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОЙЛГОЛТ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хүний эрхийн Түгээмэл тунхаглалд “... эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээлгэн тогтоолгох эрхтэй”(www.legalinfo.com, 1948) гэж, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12-д “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” (www.legalinfo.mn, 1992) гэж тус тус заажээ.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнийг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүднээс төрийн эрх барих байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллага, төрийн байгууллагуудыг шинэчлэн зохион байгуулахад ач холбогдол бүхий хуулиуд батлан гарсан билээ.

2017 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж, шүүхээс гаргасан шийдвэр, шүүхээр баталгаажуулсан нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, захиргааны шийтгэвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын эд хөрөнгө, зардал гаргуулах, хохирол нөхөн төлүүлэх заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураах гэх мэт албадлагын шинж чанартай ажиллагааг гүйцэтгэхдээ процессын хэм хэмжээгээр зохицуулах шаардлагатай болдог ч дээрх байдлууд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн материаллаг хэм хэмжээг зөв хэрэглэх баталгаа болж өгдөг (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, 2006).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн материаллаг хэм хэмжээ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талуудын эрх үүргийн агуулгыг тодорхойлж, эрх үүргээ хэрэгжүүлэхийн тулд юу хийх ёстойг зааж өгдөг бол процессын хэм хэмжээгээр талуудын дурдсан эрх үүргийг ямар журам хэлбэрээр гүйцэтгэж болохыг заадаг байна.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд тусгай бие даасан үе шат байдлаар авч үзэх нь энэхүү ажиллагааны зарчим, мөн чанар, ажиллагаанд оролцогчдын бүрэн эрх, албадан биелүүлэх ажиллагааны журамтай салшгүй холбоотой гэж үзэж болно.

Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, тасралтгүй, жигд хүртээмжтэй хүргэж, иргэд хоорондын хэрэг маргааныг шүүн таслах, хуулиар зохицуулагдсан харилцааны хэвийн үйл ажиллагааг хангах явдал төрийн байгууллагын үүрэг билээ.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхтэй холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах, харьяалал тогтоох, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, эдийн бус хөрөнгөөс төлбөр гаргуулах, тодорхой үүрэг гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг даалгах, орон сууц, байшин барилга, байгууламж, агуулах сав газар чөлөөлөх, нураах, хүүхэд гаргуулах, шилжүүлэх, ажилд эргүүлэн томилох тухай шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагааг хэлнэ.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгч субъектээс хамаарч төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээд гэж шийдвэр гүйцэтгэх гүйцэтгэх арга, журмаас нь хамааран мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа, эд хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа, эд хөрөнгийн бус шаардлага буюу тодорхой үүрэг гүйцэтгэх, гүйцэтгэхгүй байхыг даалгасан шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа, тэжээн тэтгэх үүрэг буюу хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа гэж хуваан авч үзэж болно.

Шийдвэр гүйцэтгэгч, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тогтоосон төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, эсхүл үнэт цаас, түүнчлэн үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөөс төлбөрийг албадан гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дарааллыг баримтална. Түүнчлэн төлбөр төлөгчийн “эдийн бус хөрөнгө”³⁸, (www.legalinfo.mn, 2002), хуваарьт хөрөнгө (УИХ, 2002) хэсгээр буюу хамтран өмчлөх төлбөрийн шаардлага хангахуйц хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг зохион байгуулдаг.

Төлбөр төлөгч, түүний хөрөнгийн талаар мэдээлэл цуглуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Төрийн байгууллагуудын лавлагааны нэгдсэн систем”-ээс мэдээллийг хүлээн авах бөгөөд цахим системд холбогдоогүй төрийн болон бусад байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хариуг авч, хөрөнгө тогтоогдсон даруйд иргэний гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг судаллаа. Үүнд:

1. Иргэний хэргийн талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр нийт 41850 гүйцэтгэх баримт бичгийн 4.5 их наяд төгрөгийг биелүүлэхээс 7836 гүйцэтгэх баримт бичгийн 369.1 тэрбум төгрөгийг биелүүлж, 34014 гүйцэтгэх баримт бичгийн 4,1 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн


³⁸ Гуравдагч этгээдэд холбогдох бараа, ажил үйлчилгээ нийлүүлсний төлбөрийг шаардах эрх, гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгчийн шаардах эрх, оюуны өмчийг эзэмших, ашиглах, өмчлөх болон тэдгээртэй холбоотой шаардах эрх, төлбөр төлөгчийн эдийн бус бусад хөрөнгийг эдийн бус хөрөнгө гэнэ.

бодит биелэлт 18,7 хувь, мөнгөн дүнгийн 8,3 хувьтай, шүүхээс шинээр 12807 гүйцэтгэх баримт бичиг нэмэгдэж ирсэн байна.

2. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр нийт 6.9 тэрбум төгрөгийн 278 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхээс 911,1 сая төгрөгийн 59 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 6,0 тэрбум төгрөгийн 219 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, бодит биелэлт 21,2 хувь, мөнгөн дүн 13,2 хувийн үзүүлэлттэй байна.

3. Хүүхдийн тэтгэлгийн биелүүлбэл зохих 14835 гүйцэтгэх баримт бичгийн 31.3 тэрбум төгрөг биелүүлэхээс 335 гүйцэтгэх баримт бичгийн 5,0 тэрбум төгрөгийг биелүүлж, 14500 гүйцэтгэх баримт бичгийн 26.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 2,2 хувьтай, шүүхээс шинээр 697 гүйцэтгэх баримт бичиг шинээр нэмэгджээ (алба, 2025).

Хүснэгт №1. Гүйцэтгэх баримт бичгийн биелэлт. /2025 оны 1 дүгээр улирлын байдлаар/



Дээрх судалгааны дүнг нэгтгэн дүгнэхэд 2025 оны эхний улирлын байдлаар иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт гүйцэтгэх баримт бичгийн хувьд 18,7 хувь, мөнгөн дүнгийн бодит биелэлт 8,3 хувь байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хангалтгүй явагдаж байгааг харуулж байна гэж үзлээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал (алба Ш.-ы. ш., 2024).



Хүснэгт №2. Төлбөр төлдөггүй шалтгаан, нөхцөлийн судалгаа

Төлбөр хийгдээгүй шалтгаан					
Оршин суугаа хаяг тодорхойгүй	Хорих ял эдэлж байгаа	Эрэн сурвалжлаг даж байгаа	Төлбөрийн чадваргүй	Хэсэгчлэн төлж байгаа	Бусад
152	658	172	161	86	32785
4,131,371,9	13,901,509,5	4,920,866,5	10,198,596,5	66,758,416,5	4,000,383,243,2
0,4%	2%	0,5%	0,5%	0,2%	96.4%

Төлбөр төлөхгүй байгаа шалтгаан, нөхцөл нь тодорхойгүй бусад гэдэг ангилалд нийт гүйцэтгэх баримт бичгийн 96,4 хувь байгаа нь шийдвэр гүйцэтгэгч нарын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

ГУРАВ. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 1877 онд батлагдаж 1950, 1990 онуудад өөрчлөлт орсон Иргэний процессын хуулийн 5 дугаар бүлэг 704-945 дугаар зүйлүүдэд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмыг зохицуулсан байдаг бөгөөд уг хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийтлэг үндэслэл, төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах, хуулийн этгээдийн төлбөрийг төлүүлэх журам зэргийг тогтоож өгсөн бол тус хуулийн 166, 753, 808, 831 дүгээр зүйлүүдэд ба Шүүхийн байгууламжийн тухай хуулийн 154 дүгээр зүйлд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлжээ.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсад шүүхийн шийдвэрийг 3-н хэлбэрээр гүйцэтгэдэг.

Үл хөдлөх эд хөрөнгийг албадан хураан авах ажиллагаа эдийн засгийн хувьд хамгийн оновчтой ашигтай шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг бөгөөд энэ нь төлбөр төлөгчид хүнд тусдаг байна.

Энэ аргыг 3-н тохиолдолд хэрэглэдэг:

1. Үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах
2. Төлбөр авагчид албадан шилжүүлж өгөх
3. Үл хөдлөх хөрөнгийг хурааж зээлээр худалдан борлуулах газарт шилжүүлж мөнгийг нь оруулах.

Төлбөр авагчийн өргөдлийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийг хурааж шүүхийн шийдвэрийн дагуу худалдан борлуулдаг бөгөөд төлбөр авагчид төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг танилцуулснаар төлбөр авагч өөрийн төлбөрөө бүрэн барагдуулах боломжтой зарагдах үл хөдлөх эд хөрөнгийг сонгоно.

Үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах журам нь хөдлөх эд хөрөнгийг худалдахтай адил явагддаг ба үл хөдлөх эд хөрөнгийг хурааж авсны дараа дуудлага худалдааг шүүхийн танхимд эсвэл тухайн шүүхийн тойрогт заасан байрлалд явуулна.

Дуудлага худалдаа явагдахаас зургаан долоо хоногийн өмнө дуудлага худалдаа явуулах тухай шүүхийн шийдвэр гарсан байх ёстой байдаг.

Тухайн шүүхийн шийдвэрт:

- Дуудлага худалдаанд оруулах эд хөрөнгийн тухай
- Дуудлага худалдаа явагдах огноо, газар
- Дуудлага худалдаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар явагдаж байгаа гэдгийг заавал тусгасан байх ёстой.

Үл хөдлөх эд хөрөнгө нь тухайн эд хөрөнгийн хамгийн доод үнээс багагүйгээр, бусдаас хамгийн өндөр үнэ амласан этгээдэд худалдагдах бөгөөд хамгийн бага үнэлгээ нь төлбөр авагчийн төлбөрийн шаардлагыг хангахуйц хэмжээнд байх ёстой.

Дуудлага худалдаа дуусаад төлбөр авагч шаардлагатай хэмжээний төлбөрөө авсны дараа төлбөр авагчийн гомдол барагдаж төлбөр барагдсан тухай мөн шүүхийн тогтоол гарна.

Энэ шүүхийн тогтоолын үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэлийн газар бүртгэл хийгдэх ажиллагаа явагдсаны дагуу төлбөр төлөгч тухайн үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхээ алддаг бөгөөд төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаа явуулахгүйгээр төлбөр авагчид шилжүүлэх ажиллагаа шүүхийн шийдвэрийн дагуу явагддаг байна.

Энэ тохиолдолд төлбөр авагч үл хөдлөх хөрөнгийг өөрийн эзэмшилд биечлэн авах хүртэл төлбөр төлөгч чанар байдлыг нь муутгахгүйгээр зориулалтын дагуу ашиглаж болдог ба хэрхэн ашиглаж байгаад нь шийдвэр гүйцэтгэгч хяналт тавина.

Төлбөр төлөгч төлбөрөө төлөх ямар ч боломжгүй, эд хөрөнгөгүй тохиолдолд шүүхээс түүнд итгэл үзүүлэх буюу тангараг өргүүлэх замаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх төрөл байдаг. Энэ тохиолдолд төлбөр төлөгч төлбөрийг хэсэгчлэн төлдөг бөгөөд шүүхийн шийдвэр биелэгдсэн гэж үздэг байна.

ХБНГУ-д үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар доод тал нь 30 хувиас доош үнээр худалддаг тул хэзээ ч зах зээлийн үнээр заргадаггүй, мөн төлбөр төлөгчийн шүүхийн шийдвэртэй төлбөр нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн үнийн 7 хувиас дээш байх ёстой. Хэрэв 7 хувиас доош үнэтэй байвал дуудлага худалдаагаар худалдан борлуулдаггүй байна.

ХБНГУ-д дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулдаг бөгөөд энэ арга нь бусад байгууллага болон албан тушаалтны нөлөөлөлд автахгүй сайн талтай байдаг байна.

Хууль зүйн яамны харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сайт дээр дуудлага худалдаа зарлагдаж, тухайн дуудлага худалдаанд оролцохын тулд гарааны үнийн 5 хувийг пластик картаар төлж кассанд байршуулан, бүртгүүлсний дараа дуудлага худалдаанд оролцогчийн үнэмлэх авна. Хэрэв дуудлага худалдаанд ялсан тохиолдолд 3 хоногийн дотор үлдсэн бүх мөнгийг төлөх ёстой.

Албадан цахим дуудлага худалдаа явуулах хугацаа нь 10 хоног байдаг бөгөөд тухайн хугацаа дуусаад 10 минут өнгөрөхөөс өмнө дахин өндөр үнийн санал орж ирсэн тохиолдолд дахин 10 минутаар сунгагдах зарчмаар явагддаг байна. “Цахим хэлбэрээр дуудлага худалдаа явуулж буй Герман улсын туршлага нь дуудлага худалдааг нээлттэй, ямар нэгэн хээл хахууль зэргээс хамгаалж чадаж буй сайн туршлага юм” (<http://issuu.com>, 2014)

ДҮГНЭЛТ

Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдүүд аль болох төлбөр төлөхөөс зайлсхийх, эд хөрөнгөө нуух, бусдад шилжүүлэх, шүүхийн шийдвэрийг дүр эсгэн биелүүлэх нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашрах нөхцөлийг бүрдүүлж байна.

Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн зүгээс гаргаж буй шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийж байгаа үйлдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож шийдвэрлэх нь төдийлөн хангалтгүй байгаагаас шүүхийн шийдвэр биелэгдэхгүй удаашрах нөхцөл үүсэж байна.

Гадаадын зарим улсад шүүхийн шийдвэрээр төлбөртэй төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээд нь шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн тохиолдолд торгууль болон хорих ялаар шийтгэдэг нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх хөшүүрэг болдог онцлогтой байна гэж үзлээ.

Мөн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан журамлаагүй, зохицуулалт дутуу байгаа энэ үед захиргааны байгууллага албан тушаалтанд тухайн шийдвэрийг биелүүлэх албадлага хэрэглэх боломж учир дутагдалтай байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг үл тоомсорлодог, захиргааны байгууллага, албан тушаалтнаас дарамт шахалт ирдэг бөгөөд шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эрх зүйн хамгаалалт, чадамж муу байдаг.

САНАЛ

Энэхүү судалгааны ажил, дүгнэлтдээ үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх талаар дараах саналыг гаргаж байна.

Нэг. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1. Албадан дуудлага худалдаанд оруулах үнийг оролцогчид харилцан тохиролцон тогтоохоор хуульчилсан байдаг. Гэтэл зарим төлбөр төлөгч нар үнийн санал өгөхөөс санаатайгаар зайлсхийж, шинжээчийн үнэлгээнд гомдол гарган шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд санаатай саад учруулдаг. Хөндлөнгийн шинжээчийн тогтоосон үнэлгээнд гомдол гаргах эрхгүй байхаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын системийг сэргээн, шийдвэр гүйцэтгэгч нарыг урамшуулалтай болгох,

Хоёр. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

1. Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн хүчин төгөлдөр гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн бусдын өмчлөх эрхэнд халдах онцгой эрхийг хэрэгжүүлдэг учраас тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлж, мэргэшүүлэх, мэргэжлийн болон ёс зүйн өндөр соёлтой байх шаардлага тавих,

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн хувийг өмнөх онтой харьцуулдаг жишиг, мөн шийдвэр гүйцэтгэгч нарын сарын бодит биелэлтийн хувиар жишдэг системийг шинэчилж, өөр аргачлалаар дүгнэх арга барил нэвтрүүлэх;

Гурав. Үйл ажиллагааны хүрээнд:

1. Тэтгэлэг төлөгч тодорхой эрхэлсэн ажилгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэлтийн төвд бүртгүүлэх ажиллагааг

явуулдаг болох мөн тухайн төлбөр төлөгчийг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах,

2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулж саад учруулж буй төлбөр төлөгч болон захиргааны байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох албадлагын нөлөөллийн арга хэмжээг бий болгох шаардлагатай байна гэж үзлээ.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он,
2. Монгол Улсын үндсэн хууль 1992 он,
3. Иргэний хууль 2002 он,
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он,
5. Э.Нармандах “Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” 2014 он,
6. Ц.Дашзэвэг – “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2006 он

---o0o---